			2. Цаг агаарын тоон динамик загваруудын тасралтгүй хэвийн ажиллагааг хангаж ажиллах, WRF, MM5, ADAM загваруудын бодолтын ирц хувь	ирц 90%	ирц 95%-иас доошгүй	2023/01/01-2023/10/31 байдлаар ECMWF-99.7%, NCEP_GFS-99.8%, JMA_GSM-99.8% - Жилийн биелэлт-99.7% - Цаг агаарын урьдчилсан мэдээ гаргахад ашигласан аргын тооцоо, тоон загваруудын үр дүнгийн бодолтыг бүртгэсэн. 1-10 сарын байдлаар тоон загварын бодолтын нийт 1824 удаа хийх ёстойгоос 1761 бодолт бүрэн хийгдэж 96.5%-ийн биелэлттэй, 63 удаа буюу 3.5%-ийн тасалдалтай байна. - Бодолт тасалдсан шалтгаан: Загварын бодолтын явцад алдаа гарч саадсан(31%), мэдээ татаж чадаагүй болон ирээгүй (30%), SQL-рүү бичиж чадаагүй (17%), суперкомпьютер унтарсан (22%), гэсэн шалтгаануудаас болж бодолтууд ороогүй. - Тасралтгүй байдлыг хангахын тулд 192.168.100.47 сервер дээр WRF(UM) загварын бодолтыг бодуулж ажиллуулсан. Суперкомпьютерийн багтаамжийг хянаж, суллах ажил байнга хийгдэж байна.	100
			3. Цаг агаарын богино, дунд хугацааны тоон динамик загварууд, статистик аргуудын алдааг үнэлэх, таарцыг сар бүр дүгнэх, тайлан гаргах, Прогнозын дундаж таарц, хувь, он	Прогнозын дундаж (температур, хур тунадас, салхи) таарц-75%	Прогнозын дундаж (температур, хур тунадас, салхи) таарц-80%-иас доошгүй.	Цаг агаарын урьдчилсан мэдээ гаргахад ашигласан аргын тооцоо, тоон загваруудын үр дүнг сар бүрийн эхний 10 хоногт дүгнэж тайланг зөвлөмжийн хамт ЦУОШГ-УМХ-т орон нутгийн синоптик инженерүүдэд хүргэж ажиллаж байна. Жилийн эцсийн (1-10 сараар) байдлаар нийт арга, загваруудын дундаж таарц 81.4%-ийн үзүүлэлттэй байна. Температурын прогнозын дундаж таарц 75.5%, хур тунадасны прогнозын дундаж	100

1	2	3	4	5	6	7	8
						таарц 83.3%, салхины прогнозын дундаж таарц 88.7%-тай байна.	
			4. Олон улсын төвүүдийн прогноз зургийн боловсруулалтын тасралтгүй үйл ажиллагааг хангаж, мэдээ хүлээн авалтын ирц	Мэдээний ирц- 95	Мэдээний хүлээн авалт 98%-аас дээш	2023 оны 5-р сарын 31-ний байдлаар: /Ерөнхий дундаж-99.3%/ -Дунд хугацааны урьдчилсан мэдээний Европын төв (ECMWF) Төлөвлөсөн-302, Гүйцэтгэл-301, Хувь-99.6%. -АНУ-ын Хүрээлэн буй орчны судалгааны үндэсний төв (NCEP) Төлөвлөсөн-604, Гүйцэтгэл-602, Хувь-99.6%. -Японы цаг уурын агенлагийн тоон загварн төв (JMA-GSM) Төлөвлөсөн-604, Гүйцэтгэл-603, Хувь-99.8%.	100
			5. Цаг уурын байран хиймэл дагуулын үүлний зургийг хэрэглэгчид хүргэх үйл ажиллагааг хангаж, FY4A, HIMAWARI-8 байран хиймэл дагуулын үүлний зургийн боловсруулалтын ирц	Мэдээний хүлээн авалтын ирц 92%	Байран хиймэл дагуулын мэдээг 95%-аас доошгүй	2023 оны эхний 10 сарын байдлаар HIMAWARI-9 байран хиймэл дагуулын 14400 удаагийн мэдээ хүлээн авахаас 14217 удаагийн мэдээг хүлээн авсан, 183 удаагийн мэдээ тасарсан. Тасарсан шалтгааны хувьд интернэтийн тасалдал, Японы цаг уурын агентлагаас мэдээний сервер болон техник үйлчилгээтэй холбоотой байсан.	98.7
			6. 2022 онд үйлдвэрлэлд туршсан арга, загваруудын дундаж таарц хувь	Тайлангийн үр дүнг 1 удаа семинараар хэлэлцүүлж, арга загваруудын жилийн дундаж таарц 75%	Прогнозын дундаж (температур, хур тунадас, салхи) таарц-80%-иас доошгүй байна. Тайлангийн үр дүнг 2 удаа семинараар хэлэлцүүлнэ.	· 2022 онд үйлдвэрлэлд туршсан аргуудын нэгдсэн дүнг гаргасан. 2022 оны ерөнхий таарц нь 81.3 %-тай, өмнөх оноос 1.5%-иар дээгүүр байсан. Ерөнхий таарцаас харвал хамгийн сайн таарцтай байгаа нь тунадасны хувьд WRF(GFS) загвар 86.9%, температурын хувьд MM5- MOS болон 2022 оны 5-р сараас үйлдвэрлэлд нэвтэрсэн ECMWF-MOS экстремал аргууд 83.8-86.6%, салхины хувьд WRF/UM/ загварын засварласан утга WRF/UM/, WRF-CDF, WRF-MOS болон WRF-CMOS аргууд 90.2-92.5%-н таарцтай байна. 2022 оны аргын үр дүнг ЦАОТЗСХ болон УМХ-д танилцуулж тайлан бичив. Мөн дотоод сүлжээн дээр тайланг байршуулав	100
				ургамалжилтын индексийн	Ургамал бүрхэвчийн 18ш/360ш	18ш/360ш зураг/мэдээ	100

1	2	3	4	5	6	7	8
6.2	Ган, зудын эрсдэлийн үнэлгээний орон зайн нарийвчлалыг сайжруулах / ЗГ-ын 2015 оны 286 дугаар тогтоол/	УТ-УЗ	1.Хиймэл дагуулын мэдээлэл ашиглаж орчны төлөв байдлын тандан судалгаа хийсэн бүтээгдэхүүн буюу зураг/мэдээний тоо.	18ш/360ш зураг/мэдээ	зураг/мэдээ 10 хоног тутамд хийж бүтээгдэхүүнийг www.icc.mn цахим хуудсанд байрлуулж, нийтэд үйлчилнэ.	Англи, Монгол хэл дээр хийж, тайлбарын хамт www.icc.mn цахим хуудсанд, мөн www.eic.mn цахим хуудасны Гамшгийн мэдээллийн санд байршуулав.	
				1.2.Ургамалжилтын индексийн олон жилийн хазайлтын 18ш норм зураг, 18ш хазайлтын зураг/мэдээний	18ш норм зураг, 18ш хазайлтын зураг/мэдээ гаргасан байна. www.icc.mn цахим хуудсанд байрлуулж, нийтэд үйлчилнэ.	18ш зураг/мэдээ боловсруулж, Монгол/Англи хэл дээр www.icc.mn –д байршуулав.	
				1.3. Гангийн индексийн 12ш зураг/мэдээ	12ш зураг/мэдээ 6-9 сард 10 хоног тутамд хийж бүтээгдэхүүнийг www.icc.mn цахим хуудсанд www.eic.mn гамшгийн мэдээллийн санд байрлуулж, нийтэд үйлчилнэ.	12ш зураг/мэдээ Англи, Монгол хэл дээр хийж, тайлбарын хамт www.icc.mn цахим хуудсанд байршуулав.	
				1.4. цасан бүрхцийн 20ш зураг/мэдээ	Цасан бүрхцийн 20 орчим зураг/мэдээ 10 хоног тутамд болон захиалгат аймгуудын нутгаар хийж бүтээгдэхүүнийг www.icc.mn , www.eic.mn , гамшгийн мэдээллийн санд, “Цаг агаар” аппликэйшнд тус тус байрлуулж, нийтэд үйлчилнэ.	Цасан бүрхүүлийн зураглалыг 10 хоног тутамд (сард 3 зураг/мэдээ) нийт 20 зураг/мэдээ, 20 статистик мэдээ, аймаг бүрээр мэдээ бэлтгэх (сард 63 зураг/мэдээ, жилд 378 зураг/мэдээ) боловсруулж, www.icc.mn цахим хуудсанд, мөн www.eic.mn цахим хуудасны Гамшгийн мэдээллийн санд байршуулж, нийтэд үйлчлэв.	100

1	2	3	4	5	6	7	8
				1.5.Газрын гадаргын температурын 36ш зураг/мэдээ	36ш зураг/мэдээ 10 хоног тутамд 10 дахь өдрийн мэдээгээр хийж бүтээгдэхүүнийг www.icc.mn цахим хуудсанд байрлуулж, нийтэд үйлчилнэ.	Газрын гадаргын температурын зураглалыг 10 хоног тутамд (сард 3 зураг/мэдээ) нийт 36 зураг/мэдээ боловсруулж, www.icc.mn цахим хуудсанд байршуулан, нийтэд үйлчлэв	100
				1.6.Ой хээрийн түймрийн зураг/мэдээний тоо 43 ш зураг/мэдээ	40-140 орчим зураг/мэдээ бүтээгдэхүүнийг www.icc.mn , www.eic.mn гамшгийн мэдээллийн санд, “Цаг агаар” аппликэйшнд тус тус байрлуулж, нийтэд үйлчилнэ.	2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн байдлаар 14 аймгийн 42 суманд 101 удаагийн ой, хээрийн түймэр бүртгэгдсэн байна. Давтагдсан тоогоор нийт 147 ш ой, хээрийн түймрийн зураг/мэдээ гаргаж www.icc.mn цахим хуудсанд болон гамшгийн мэдээллийн санд байршуулсан. Мөн холбогдох газруудад мэдээлсэн. Хавар болон намрын улиралд шатсан талбайн хэмжээг тодорхойлсон. 10 сарын 09-ны өдрийн байдлаар 32,638 км.кв талбай шатсан байна.	100
	Зорилт 7 Супер-компьютерийн технологид суурилсан ус, цаг агаар, орчны загварчлалын системийг өргөжүүлэн, хөгжүүлэх /Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө/	710.0 сая.төг УТ-УЗ	Супер-компьютерын технологид суурилсан ус, цаг агаар, орчны загварчлалын системийг өргөжүүлэн, хөгжүүлэх хувь/тоо	Суперкомпьютерын технологид суурилсан ус, цаг агаар, орчны загварчлалын системийг өргөжүүлэн, хөгжүүлэх үзүүлэлтийн нарийвчлал багатай байсан.	Супер-компьютерын технологид суурилсан ус, цаг агаар, орчны загварчлалын системийг өргөжүүлэн, хөгжүүлэх үзүүлэлтийн нарийвчлалыг сайжруулан 1-5км болгон урьдчилсан хугацааг 7-10 хоног болгон нэмэгдүүлнэ.	WRF загварын прогноз урьдчиллын хугацааг 10 хоног руу туршилтаар бэлэн болсон. Ашиглахад бэлэн болсон.	100

1	2	3	4	5	6	7	8
7.1	Цаг агаарын тоон загварыг таарц, орон зай, цаг хугацааны нарийвчлалыг сайжруулах /Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 6.1.3/	УТ-УЗ	1.Цаг агаарын тоон загварын үр дүн хувь	Орон зайн 10 км, 5 хоногийн урьдчилалтай байв.	Орон зайн 1-5 км, 7-10 хоногийн урьдчилалтай болгох.	WRF загварыг Монгол орны хэмжээгээр 5 км алхамтайгаар, 6 хоногийн урьдчилалтай өдөрт 2 удаа шуурхай бодогдож байна. WRF загварын прогноз урьдчиллын хугацааг 10 хоног руу туршилтаар шилжүүлэв. 2022 оноор турших ажил хийгдсэн.	100
			2.Хур тунадасны илрүүлэлтийн хувь	75%	80%	Прогнозын дундаж таарц хур тунадасны хувьд 83.3% байна.	
7.2	Орчил урсгалын олон загварын ансамбль системийг боловсруулж нэвтрүүлэх /Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 6.1.3/	УТ-УЗ	1.Загварын тоо	1. 5	1. 6	Олон загварын ансамбль системийн оролтын параметруудийг туршиж байна. Гарсан үр дүнг сар, улирлын урьдчилсан төлөв гаргахад ашиглаж байна.	100
			2.Ансамбль гишүүний тоо	2. 10	2. 10		
7.3	Агаарын бохирдлын тархалтын загварчлалын арга технологийг боловсруулж, нэвтрүүлэх /Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 6.1.7/	УТ-УЗ	1.Загварын үр дүнг харьцуулан үнэлгээ хийсэн цэгийн тоо	-	10	Агаарын бохирдлын ADAM-Haze загварын үр дүнг агаарын чанарын 13 харуул дээрх ойролцоох цэгүүдийг тодорхойлж загварын агаарыг бохирдуулагч бодисууд (SO ₂ , CO, NO ₂ , O ₃ , PM ₁₀ , PM _{2.5}) утгуудыг 2023 оны 1-р сарын 1-с 10-р сарын 31 хүртэл автоматаар татан авч хадгалсан. ADAM-Haze загварын 1 км нь нийт 606 бодолт хийхээс бодолт хийж 34 бодолтыг загварын 9км-ын үр дүнгээс нөхөж бодуулав. Загварын прогноз утга PM ₁₀ -ын хувьд бодит утгатай харьцуулахад дундаж алдаа 40-60%, SO ₂ -ын хувьд дундаж алдаа 30-40% байна.	100
			2. Тоон динамик загвар WRF, MM5, ADAM загваруудын бодолтын ирц	2.90%-аас дээш	2.95%-аас доошгүй		
			3.Богино, дунд хугацааны тоон динамик загварууд, статистик аргуудын Прогнозын дундаж таарц	75%	80%-аас доошгүй	Агаарын бохирдлын WRF-Chem загварын үр дүнг агаарын чанарын 18 харуул дээрх ойролцоох цэгүүдийг тодорхойлж загварын агаарыг бохирдуулагч бодисууд (SO ₂ , CO, NO ₂ , O ₃ , PM ₁₀) утгуудыг 2023 оны 1-р сарын 1-с 10-р сарын 31 харьцуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Visual studio програм дээр ADAM болон WRF-Chem загварын үр дүнг зэрэгцүүлэн оруулах хэсгийг нэмж бичсэн.	100
			4.2022 онд үйлдвэрлэлд туршсан аргуудын нэгдсэн дүнг гаргаж, тайлангийн үр дүнг 2 удаа семинараар хэлэлцүүлэх	4.Тайлангийн үр дүнг 1 жилийн дундаж таарц 75%	4.Тайлангийн үр дүнг 2 удаа семинараар хэлэлцүүлж, арга загваруудын жилийн дундаж таарц 80%-аас доошгүй		

1	2	3	4	5	6	7	8
						Агаарын бохирдлын индексийн прогнозыг бодит индекстэй харьцуулахдаа 2023 оны 7-ээс 9 сарын 20-ны өдрийн мэдээний хоногийн явцыг гаргаж өмнө загварт оруулсан хоногийн явцтай элемент бүрээр харьцуулан үзэж байна. Сервер эвдэрсэнтэй холбоотой тухайн системийг бүхэлд нь супер-лүү шилжүүлж тохируулах ажил хийгдсэн. Систем болон вэб дээр жижиг алдаануудыг зассан.	
	Зорилт-8 Уур амьсгалын өөрчлөлтийн Монгол орны экосистемд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг нарийвчлан хийх /Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө/	12.0 сая.төг УТ-УЗ	Уур амьсгалын өөрчлөлтийн Монгол орны экосистемд үзүүлэх нөлөөллийн нарийвчлан үнэлгээ хийгдсэн тоо, судалгааны тайлангийн тоо	1.80 станцын 1961-2021 оны мэдээгээр уур амьсгалын 80 экстремал индексийг тооцоолсон. Судалгааны үр дүн гарсан /1980 он/	1.80 станцын 1961-2022 оны мэдээгээр уур амьсгалын 80 орчим экстремал индексийг тооцоолж, үр дүнг цахим сайтад байрлуулна. Доорх байдлаар илэрхийлэгдэнэ.	Урт цуваат 80 станцын 1961-2021 оны экстремаль индекс тооцоолдог хоногийн цувааг 2022 оноор уртасгаж, 80 гаруй экстремал индексийг тооцоолж, үүнээс монгол орны нийгэм эдийн засагт хамгийн их нөлөө үзүүлж буй уур амьсгалын 11 экстремал индексийг сонгон авч мониторинг хийж, үр дүнг цахим сайтад байршуулсан.	100
8.1	Агро уур амьсгалын нөөц, түүний өөрчлөлтийг нарийвчлан тодорхойлох /Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 6.1.3/	УТ-УЗ	Судалгааны тайлангийн тоо	Судалгааны үр дүн гарсан /1980 он/	Идэвхтэй, ашигтай температурын орон зайн 10-20 км нарийвчлалтай зураглал гаргаж, түүний олон жилийн өөрчлөлтийг тодорхойлж, тайлан бичсэн байна.	Цаг уурын тулгуур 100 гаруй өртөөний 8-н хугацааны ажиглалт хийж эхэлсэн 1975 оноос хойших хоногийн дундаж агаарын температурын цувааг бүрдүүлж, нэгэн төрлийн болгож, уур амьсгалын тооцооны температурын (+5, +10°C) эхлэх, дуусах хугацаа, үргэлжлэх хоногийг тооцоолсон. Тооцоолсон бодит ажиглалтын мэдээг ашиглан статистик загвараар орон зайн 10 км-ын нарийвчлалтай грид мэдээлэл үүсгэж, Монгол орны өндөр нарийвчлалтай хэрэглээний уур амьсгалын зураглалыг зохиосон.	100
	Зорилт-9 Цаг уур, орчны шинжилгээний салбарыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, үйл ажиллагааны менежментийг	2,630.0 УТ-УЗ		1.1. Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын хэвийн үйл ажиллагаа хангагдаж, газар	1.1. Ус, цаг агаар, байгаль орчны төлөв байдалд байнгын хяналт шинжилгээ хийж,	2023 оны "Цаг уур, орчны шинжилгээний салбарын жил болгон зарлаж албан хаагчдын нийгмийн баталгаа, цалин, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр салбарын сайдын санаачлагаар нийт 1893 албан хаагчийн цалин,	96.5

1	2	3	4	5	6	7	8
	боловсронгуй болгох, салбарын удирдлагын манлайллыг хангах, салбарын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, харьяа байгууллагуудад технологийн болон санхүүгийн дотоод хяналт шалгалт хийх, архив, албан хэрэг хөтлөлтийн ажлыг хариуцах /Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө/		1.Холбогдох хууль, тогтоомж, байгууллагын стратегийн төлөвлөгөө хэрэгжсэн байх	болон харьяа 3 байгууллага, 22 төвд 1893 албан хаагч ажиллаж, цаг агаар уур амьсгал судлалын 137 өртөө, 181 харуул, ус судлалын 154 харуул, цаг агаарт нөлөөлөх 45 экспедиц, орчны хяналт шинжилгээний 22 лаборатори ажиллаж байна. Тус газарт санхүүгийн болон технологийн аудит хариуцсан албан хаагч ажиллаж байна. Архивын тухай хууль, байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн талаар гарсан Засгийн газрын тогтоол болон баримт бичгийн стандарт, заавар журмын дагуу архивын болон албан хэрэг хөтлөлтийн ажлыг эрхлэн явуулах стандартыг чанд мөрдөн ажиллаж, хадгалалт хамгаалалт үйлчилгээг хариуцан ажиллаж байна.	бодит болон урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг шуурхай хангах, байгалийн болзошгүй гамшгийн эрсдэлээс сэрэмжлүүлэх ажлыг хэвийн, байнгын тасралтгүй явуулах боломжийг хангаж, нэгдсэн удирдлагаар хангана.	нэмэгдэл, нэмэгдэл хөлс. 20-46 хувиар буюу сүүлийн 5 жилтэй харьцуулахад ийн байдлаар нийт цалингийн сан 2,5 дахин нэмэгдсэн. Салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын мэргэжилийн зэргийг олгох 3 сайдын хамтарсан тушаалыг 2018 оноос хойш гаргаагүй байсанг салбарын сайд, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэхүү хамтарсан тушаалаар салбарын мэргэжилийн албан хаагчид 10-25 хувийн нэмэгдэл авах боломж бүрдсэн. Байгууллагын хэвийн үйл ажиллагаа хангадаж, ард иргэд, аж нэгж байгууллагад төрийн үйлчилгээг хүргэн тасралтгүй байнгын үйл ажиллагааг ханган ажиллаа. ЦУОШГ-ын орон тооны дээд хязгаарыг баталсан Засгийн газрын тогтоолыг өөрчлөх хэрэгцээ шаардлагын талаар танилцуулга, Засгийн газрын тогтоолын болон тэмдэглэлийн төслийг боловсруулан яаманд хүргүүлсэн, Засгийн газраар уг тогтоолд өөрчлөлт орж батлагдсаны дараа байгууллагын стратегийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу бүтцийн өөрчлөлтийг хийхээр төлөвлөж байна. Салбарын хуулийг өөрчлөх ажлын хэсгийг яамнаас гарган судалгаа шинжилгээ хийх, хэрэгцээ шаардлагыг тодорхойлохоор ажиллаж байна. Газрын сул орон тооны талаарх мэдээллийг хуулийн дагуу яаманд хүргэж салбар зөвлөлөөс сонгон шалгаруулалт зарлан нөхөж байгаа ч удаашралтай, иргэдийн оролцоо, төрийн албан хаагч өрсөлдөж нөхөгдөхгүй орон тоо байсаар байна. Төрийн жинхэнэ албан хаагчийн зэрэг дэв олгох шийдвэр гарсан. Ус цаг уурчдын үндэсний зөвлөгөөнийг зохион байгуулан төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг	

1	2	3	4	5	6	7	8
						хангах, тулгамдсан асуудлуудын шийдэл, гарцын талаар зөвлөлдөн салбарын Хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж 800 орчим төлөөлөгчидөөр хэлэлцүүлж, батлуулахаар ажиллаж байна. Тус газрын даргын А/240 дүгээр тушаалаар газрын албан хаагчдын нийгмийн баталгаа, сургалтын хөтөлбөрийн батлуулсан уг хөтөлбөрийн хүрээнд 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж ажиллаа. /Дэлгэрэнгүй тайланг хавсаргав/.	
			2. Хоёр болон олон талт гэрээний хэрэгжилт, хувь	2. 95 %	2. 96%	Хоёр болон олон талт гэрээний хэрэгжилт дараах байдлаар тодорхойдогдоно.	
9.1	Байгууллагын зорилт, чиг үүргийг мэргэжлийн өндөр түвшинд хэрэгжүүлэх чадавхтай хүний нөөцийг бүрдүүлэх, хүний нөөцтэй холбоотой судалгаа, тайлан мэдээг цаг хугацаанд нь гаргах, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангах	Улсын төсөв	Холбогдох хуулийн дагуу томилгоо, тушаал шийдвэр гарч, тайлан мэдээг хугацаандаа гүйцэтгэсэн байна. Төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлсэн байна.	Салбарын хэмжээнд 21 сул орон тоо гарсанг 2022 оны 11 сард яамны Төрийн албаны салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулан нөхөх ажлыг зохион байгуулж байна. Хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн 2022 оны төлөвлөгөөний улсын төсвийн хөрөнгө шаардсан заалт Хэмнэлтийн хууль гарсантай холбогдон хэрэгжээгүй хойшилсон.	Сул болон эзгүй орон тоо хуулийн дагуу нөхөгдсөн байна. Төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байна	2023 онд Удирдлагын академийн Төрийн албаны сургуулиас зохион байгуулсан төрийн албан хаагчийг мэргэшүүлэх сургалтад 16 албан хаагч, тус газраас зохион байгуулсан мэргэжлийн чиглэлээр мэргэшүүлэх сургалтад 177 албан хаагч хамрагдсан байна. Салбарын нийт 58 ажилтныг гадаадад сургалт, хуралд хамруулж, олон нийтэд мэдээлэл хүргэж ажиллав. 2022-2023 онд БОАЖЯ-ны дэргэдэх салбар зөвлөл тус газрын харьяа төрийн үйлчилгээний удирдах албан тушаал 10, төрийн жинхэнэ албан тушаалын 16 сул орон тоон гарсаны 3 орон тоог сэлгэн болон шилжүүлэн ажиллуулсан. төрийн үйлчилгээний удирдах албан тушаал 10, жинхэнэ албан тушаалын 13 сул орон тоо нөхөгдөж, томилон ажиллуулж байна. 2023 онд шинээр төрийн захиргааны 3, төрийн үйлчилгээний 2 сул орон тоог сонгон шалгаруулахаар ажиллаж байна. Тус газрын даргын 2021 оны А/240 дүгээр тушаалаар батлагдсан тус газрын төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг газрын даргаар	100

1	2	3	4	5	6	7	8
						батлуулсан. Нийгмийн баталгааны төлөвлөгөөний тайланг хавсаргав.	
9.2	Төрийн албаны тухай хууль тогтоомж, тогтоол шийдвэр, стандартын хэрэгжилтийг хангаж, харъяа 26 байгууллага, газрын нэгжийн болон төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнах, урамшуулах	Улсын төсөв	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг тогтоол, журмын дагуу батлуулж, дүгнэсэн байх	2022 онд 26 байгууллага, 6 хэлтэс, 68 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан, хяналт, үнэлэлт өгч урамшуулал олгосон.	2023 оны 26 байгууллага, 6 хэлтэс, 68 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан, хяналт, үнэлэлт өгнө.	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын удирдах ажилтны ээлжит семинар, зөвлөгөөн, сургалтыг 2023 оны 1 дүгээр сарын 19-21-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулж, газрын харъяа 26 байгууллагын төсвийн шууд захирагч нарын 2022 оны ажлыг дүгнэж, зохих урамшуулал олгож, 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батласан. Газрын албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг газрын даргын төлөвлөгөө сайдаар батлагдсаны даргаагаар баталгаажуулан ажиллаж байна. Хагас бүтэн жилийн ажлыг хэлтэс, харъяа байгууллага бүрээр дүгнэн, Үнэлгээний багийг томилон ажиллуулж, дүнг нэгтгэн хуулийн дагуу зохих урамшуулалыг албан хаагчдад 20-40 хувь хүртэл олгох ажлыг зохион байгууллаа. Газрын болон харъяа байгууллагуудын хэвийн, тасралтгүй, байнгын ажиллах нөхцлийг бүрдүүлэн 25 байгууллагын 2023 оны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан хагас бүтэн жилийн ажлыг дүгнэн, зөвлөмж хүргүүлэн байгууллага бүрийн даргын зөвлөлөөр хэлцүүлэх, анхаарах асуудлуудыг тодорхойлон хяналт тавьж, захиргааны чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаа.	100
9.3	Төрийн жинхэнэ болон төрийн үйлчилгээний албаны Ёс зүйн зөвлөлийг ажиллуулан, тайланг холбогдох газарт хүргүүлэх	Улсын төсөв	Засгийн газрын холбогдох тогтоолыг бүрэн хэрэгжүүлж ажиллах	Газрын даргын 2020, 2022 онд газрын даргын тушаалаар Ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулан ажиллуулж байна.	Төрийн албан хаагч, иргэдээс ирүүлсэн хамаарал бүхий өргөдөл гомдолыг шийдвэрлэсэн байна.	Нийт хариутай 545 өргөдөл, хүсэлт ирсэн. Агуулгын хувьд авч үзвэл: • Цаг агаарын мэдээ хүссэн – 348 • Дэмжлэг, туслалцаа, шагнал олгуулах, жирэмсний амралт авах, ажилд орох, ээлжийн ажлын хуваарь өөрчлөх, тэтгэвэрт гарах, хүний нөөцийн чиглэлээр нийт-190 • Гомдол, санал-7 /11-11 төвөөр/ • Ёс зүйн зөвлөлөөр 1 тус тус ирсэн байна.	95

1	2	3	4	5	6	7	8
						Харин 11-11 төвөөр ирсэн гомдлыг шалгах ажлын хэсэг гарч ажиллаж байгаа бөгөөд бусад гомдол хугацаанд нь бүрэн барагдуулсан болно.	
9.4	Байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилтэд хяналт тавих, зөрчлийг илрүүлэх, арилгах дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, зөвлөмж дүгнэлт гаргах	Улсын төсөв	Шалгах төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан батлуулсан байна.	2021, 2022 оны үйл ажиллагаанд санхүүгийн болон технологийн дотоод аудитыг тухайн байгууллагуудад хийгдсэн байгаа.	2022, 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд дүгнэлт хийж, хөрөнгийн тооллого явагдсан байна.	Хавсралт хайрцаг 1.	85
9.5	Байгууллагын архив, бичиг баримтыг холбогдох хууль, тогтоомж, стандарт, заавар журмын дагуу эрхлэн явуулах	Улсын төсөв	Заавар, журам, стандартыг мөрдсөн байна.	2019 оны улсын архивын үзлэгээр хангалттай үнэлгээ авсан. Бичиг хэргийн нэгдсэн систем болох egr.e-mongolia.mn системд байгууллагын албан хаагчдыг бүрэн оруулсан, хэрэглэж эхэлсэн. Албан хэрэг хөтлөлтийн шатанд баримт бичгийн эргэлт, урсгал эмх цэгц, бүрдэл, хадгалалт, ашиглалтыг сайжирч, үйл ажиллагааны тасралтгүй, шуурхай байдлыг хангаж ажилласан.	Архивын ажил хэвийн явагдаж, 2021 оны болон 2023 жилийн тайлан гарсан байна. Баримт бичгийг эмх цэгцтэй, тасралтгүй, шуурхай байдлыг хангаж ажилласан байна.	Байгууллагын архивт хүлээн авах баримтын тоо ихэссэнтэй холбоотой архивын баримтын хадгалалт, хамгаалалтын өрөөг томсгож стандартын дагуу тусгайлан засварлан, тоног төхөөрөмж, шүүгээгээр хангаж, стандартын дагуу ажиллах нөхцлийг бүрдүүлж өгсөн. Архивын баримтын хадгалалт хамгаалалтын ажлыг зааврын дагуу мэргэжилийн түвшинд хийж, архивын баримтын өрөөний ариутгалыг нийт 3 удаа, цэвэрлэгээг нийт 76 удаа, их цэвэрлэгээг нийт 10 удаа. эрүүл ахуйн нөхцөл, гэрэл, дулаан, чийгийг нийт 75 удаа хэмжиж, стандартын түвшинд хүрэхгүй тохиолдолд авах арга хэмжээг тухай бүр стандартад нийцүүлэн ажиллалаа. 2022 оны Газрын даргын А тушаал-2 боть, Б тушаал -1 боть нийт цаасан суурьтай 8620 KB хэмжээтэй баримтын файлыг ORDERS праграммдаа байршуулах, мөн 2020-2022 оны тус байгууллагын ирсэн явсан албан бичгийг Excel-ийн Hyperlink-ээр JPG болон PDF өргөтгөлтэй файлаар шивж, эрэл хайлтыг түргэсгэх болон баримтын цахим хайлтын ажлыг эхлүүлээд явж байна. Баримтын бүртгэл үйлдэж нийт 22 хүнд давхардсан тоогоор 906 баримтыг дотоод ажлын хэрэгцээнд ашиглуулахаар олгож,	95

1	2	3	4	5	6	7	8
						буцаан хүлээн авч, хагас болон бүтэн жилийн тайланд тусгагдсан болно.	
9.6	Холбогдох конвенцын зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, Дэлхийн цаг уурын байгууллага болон олон улсын байгууллагуудтай гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх /Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 6.1.5/	732.3 УТ-УЗ	Хоёр болон олон талт гэрээний хэрэгжилт, хувь	95%	96.0%	Хавсралт хайрцаг 2	100
		17.7 УТ-УЗ	Дэлхийн цаг уурын байгууллагаас зохион байгуулсан олон улсын хурал, судалгаа, сургалтад хамрагдсан байдал, хувь	100%	100%	Хавсралт хайрцаг 3	100
		14.4 УТ-УЗ	Цаг уур, орчны шинжилгээний газар, ОХУ-ын Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний газрын хооронд Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарт шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах тухай Монгол улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх 9 дүгээр уулзалтын протоколын хэрэгжилт, хувь	92%	93%	10 дугаар уулзалтын протоколд тусгах саналуудыг холбогдох хэлтэс, байгууллагуудаар гаргуулан нэгтгэж Оросын талтай санал солилцсон бөгөөд олон улсын нөхцөл байдал /дайн/ болон бусад шалтгааны улмаас 10 дугаар уулзалтын тов гараагүй байгаа болно. 2024 онд МУ-д цаг уурын алба үүсэж, хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэх ажлын хүрээнд ОХУ-ын ЦУГ-аас 1924-1937 онд МУ-д байгуулж байсан анхны цаг уурын станцуудын баримт бичиг, ажиглалтын дэвтэр, мэдээг олж ирүүлэх талаар хүсэлтийг орчуулж газрын даргад хүргүүлэв.	93
		15.5 УТ-УЗ	БНХАУ-ын Цаг уурын газар болон Монгол улсын Цаг уур, орчны шинжилгээний газрын хооронд Цаг уурын шинжлэх ухаан, технологийн салбарт хамтран ажиллах хамтарсан ажлын хэсгийн 16 дугаар уулзалтын протоколын хэрэгжилт, хувиар	93%	95%	БНХАУ-ын Цаг уурын газартай Цаг уурын шинжлэх ухаан, технологийн салбарт хамтран ажиллах хамтарсан ажлын хэсгийн 16 дугаар уулзалтын протоколын хүрээнд мэдээллийн студийн тоног төхөөрөмжийг суурилуулж, заавар өгөх 1 мэргэжилтнийг урьж ирүүлэн 10 хоног ажиллуулав. БНХАУ-ын Нанжинг хотод болсон “Азийн бүс нутгийн уур амьсгалын хяналт, үнэлгээ, урьдчилсан төлөв” сэдэвт 19 дүгээр хуралд УЦУОСМХ-ийн ерөнхий инженер Б.Жаргаланг оролцуулах ажлыг зохион байгуулав. 16 дугаар уулзалтын протоколын хэрэгжилтийг 2 талаас гарган нэгтгэв. 2023 оны 10 дугаар сарын 10-13-ны өдрүүдэд Бээжин хотноо болсон хоёр талын 17	95

1	2	3	4	5	6	7	8
						дугаар уулзалтын бэлтгэл ажлыг хариуцан, тушаал, уулзалтын протокол, хөтөлбөрүүдийг англи, Монгол хэл дээр боловсруулах, онгоцны билет, төлөөлөгчдийн оролцоо, Монголын талаас илтгэл тавьж ажиллав. Ирэх 2 жилд Азийн шороон шуурганы хяналт шинжилгээ, түүний хамтарсан судалгаа, цаг уурын харилцаа холбоо, хиймэл дагуулын мэдээ ашиглалт, урт хугацааны урьдчилсан мэдээ, цаг агаар ба уур амьсгалын үйлчилгээ, цаг уурын ажиглалтын тоног төхөөрөмж, болон мэргэжилтэн сургах зэрэг 7 чиглэлд хамтран ажиллах гэрээг боловсруулав. БНХАУ-ын засгийн газрын “Нэг бүс, нэг зам” санаачилгын хүрээнд явагддаг мэргэжилтэн солилцооны хөтөлбөрт МУ-ын ус, цаг уурчдыг хамруулах талаар БНХАУ-ын талтай санал солилцож ажиллаж байна.	
		19.1 УТ-УЗ	Монгол улсын Цаг уур, орчны шинжилгээний газар, БНСУ-ын Цаг уурын газрын хооронд цаг уурын салбарт хамтран ажиллах 9 дүгээр уулзалтын протоколд хэрэгжилт, хувиар	92%	94%	Хавсралт хайрцаг 4	100
		УТ-УЗ	Цаг уур, орчны шинжилгээний газар болон Тайландын Хааны бороо, хөдөө аж ахуйн агаарын тээврийн газар хооронд “Цаг агаарт зориудаар нөлөөлөх талаарх техникийн хамтын ажиллагааны хамтарсан хөтөлбөр”-ийн хэрэгжилт, хувиар	95%	96%	Хамтарсан хөтөлбөрийн дагуу Тайландын талтай харилцаж мэдээллийг холбогдох мэргэжилтнүүдэд хүргэж, хугацаатай албан захидлуудад хариу хүргүүлж ажилласан. “Монгол Улсад Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг хөгжүүлэх” төслийг боловсруулж, 3 дугаар сарын 2-нд Тайландад суугаа МУ-ын элчин сайдад хүргүүлж, Тайландын эрхэмсэг гүнжийн гадаад харилцааны хэлтэс уламжилж өгөхийг хүссэний дагуу 5 сард Тайландын гүнж төслийг санхүүжүүлэхээр зөвшөөрсөн болно. Төслийн хүрээнд 7 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд газар,	100

1	2	3	4	5	6	7	8
						хүрээлэн, орон нутгийн 3 хүнийг Тайландын Хааны бороо, хөдөө аж ахуйн агаарын тээврийн газарт сургалтад хамруулсан. Тайландын мэргэжилтнүүдтэй төслийн хэрэгжилтийн талаар хамтран ажиллаж байна. Тайландын мэргэжилтэн 2024 онд ирж хамтран ажиллахаар болсон.	
		665.6 УТ-УЗ	Гадаад орнуудын цаг уурын байгууллага, цаг уурын тоног төхөөрөмж үйлдвэрлэгч компаниудтай байгуулсан гэрээний хэрэгжилт, хувиар	100.0 %	100%	Хавсралт хайрцаг 5	95
		УТ-УЗ	Монгол улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын (хилийн усыг ашиглах, хамгаалах тухай) хэрэлцээрийн дагуу мэдээ, мэдээлэл солилцсон эсэх	Тийм	Тийм	Хяналт-шинжилгээний 2022 оны үр дүнг нэгтгэн тайланг 2023 оны 3 дугаар сарын 31-ны өдөр ОХУ-ын ажлын хэсэгт цахим шуудангаар явуулсан болно. 8 сард Сэлэнгэ мөрний хил орчмын бүсээс усны биологийн дээж авах 2 орны хамтарсан экспедицэд Сэлэнгэ аймгийн УЦУОШТ-ийн усны инженер оролцов. 11 сарын 22-нд ОХУ-д болсон Хилийн усны бага хуралд ДЦУБ-ын МУ дахь төлөөлөгчийн Ус судлалын зөвлөх Д.Оюунбаатар оролцов.	100

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл- тийн хувь
1	Үүрэг даалгавар 1. Ус цаг уур, орчны хяналт шижилгээний салбарын улсын зөвлөгөөн зохион байгуулах	Өгөгдсөн үүрэг даалгаварыг бүрэн гүйцэтгэсэн байдал, хувиар	-	100%	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/418 тоот тушаалаар “Ус, цаг уурчдын улсын зөвлөгөөн” зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд Зөвлөгөөнийг 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулж Ус цаг уур, орчны хяналт, шинжилгээний салбарын хөгжлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, дэлхийн болон олон улсын цаг уурын байгууллагын хөгжлийн чиг хандлагын талаарх бодлого, үйл ажиллагаа, албан хаагчдын болон эрдэмтэн судлаачдын илтгэл, мэдээллийг сонсож, хэлэлцүүлэг өрнүүлж, гарц шийдлийг хэлэлцэн Хөгжлийн шинэ үеийг эхлүүлэхээр 21 аймгийн болон төвийн байгууллагуудын 700 гаруй албан хаагчид, гадаадын болон олон улсын байгууллагын 50 гаруй төлөөлөгчид оролцсон.	2023.08.28- 2023.10.27	100%
2	Үүрэг даалгавар 2. Төсвийн талаар тооцоо, судалгаа гаргаж хүрэлцэхүй байгаа зардлууд болон цалингийн тооцоо	Өгөгдсөн үүрэг даалгаварыг бүрэн гүйцэтгэсэн байдал, хувиар	-	100%	2022 онд төсөв 51 хувь хасагдаж батлагдснаас 329.9 сая төгрөгийн өр үүссэнийг БОАЖЯ-м болон Сангийн яаманд тооцоо судалгаа удаа дараа гарган хүргүүлсний үр дүнд Цаг уур, орчны шинжилгээний салбарын 26 байгууллагын 1893 албан хаагчдын ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх, цалин хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 2023 оны төсвийн тодотголоор 10.5 тэрбум төгрөгийг шийдвэрлэсэн.	2023.07.17- 2023.09.01	100%
3.	Үүрэг даалгавар 3. БОАЖ Сайдын багцаас шийдвэрлэсэн худалдан авах ажиллагааг зохион байгуулах	Өгөгдсөн үүрэг даалгаварыг бүрэн гүйцэтгэсэн байдал, хувиар	-	100%	БОАЖЯ-ны сайдын багцаас цаг уурын салбарын 11 байгууллагад 890.3 сая төгрөгийн багаж, техник, тоног төхөөрөмж, хэрэгслийг шийдвэрлэсэн. БОАЖ-ын сайдын багцаас 20.0 саяас дээш төсөв олгосон 7 байгууллагад 374.8 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны эрхийг нь шилжүүлж, төсвийн худалдан авалтуудыг тухай бүр цахим худалдан авалтын системд оруулах ажлыг шуурхай зохион байгуулж ажилласан.	2023.07- 2023-12	100%
4	Үүрэг даалгавар 4. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хэвлэлийн хуралд оролцож мэдээлэл хийх	Өгөгдсөн үүрэг даалгаварыг бүрэн гүйцэтгэсэн байдал, хувиар	-	100%	БОАЖЯ-наас сар бүр зохион байгуулдаг Хэвлэлийн хуралд 2023 оны 9-12 сард 3 удаа оролцож цаг үеийн асуудал, өвөлжилт, цаг агаарын төлөв болон урьдчилсан мэдээний талаар танилцуулга хийсэн	2023.09- 2023-12	100%

Товчилсон нэрийн тайлал:

УТ - ХО
УТ - УЗ
ОНТ
ГЗТ

Улсын төсвийн хөрөнгө оруулалт
Улсын төсвийн урсгал зардал
Орон нутгийн төсөв
Гадаадын зээл, тусламж

Төлөөлөгөөг хянасан:

Төсвийн Ерөнхийлөн захирагч

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД

/ Б.БАТ-ЭРДЭНЭ/

2023 оны дугаар сарын-ны өдөр

Төлөөлөгөө тайлагнасан:

Төсвийн төвлөрүүлэн захирагч

ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



/ Л.ОЮУНЖАРГАЛ /

2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр

Хавсралт хайрцаг 1. 9.4-ийн биелэлт

Төрийн аудитын байгууллагаар баталгаажсан тайланг нэгтгэв. Аймаг орон нутаг, харьяа байгууллагуудын 2021 оны жилийн эцсийн болон 2022 оны 1,2 дугаар улирлын тайланг гаргаж БОАЖЯ-эд хүргүүлэв. ДЦУБ-аас гаргасан заавар, зөвлөмжийн бүртгэл, жагсаалт гаргаж, баримт бичгийг орчуулан Олон улсын стандарт, зөвлөмжийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох зорилгоор WMO-No.1202 заавар, зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. ДЦУБ-ын бүсийн Ажиглалтын Нэгдсэн Систем /RWC/-ээс ирүүлсэн мэдэгдэлийн дагуу цаг уурын 17 өртөөдийн алдаатай Мета өгөгдөлийг засаж оруулав. Мөн бусад өртөөдийн мэдээллийг хянах, засварлах ажил хийгдэж байна. RWC Токио төвөөс ирүүлсэн тайланд дурдсанд манай аэрологийн ажиглалтын чанарт асуудал гараагүй байна. RBON key regional challenges хариу өгсөн

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний Ус, цаг агаар, байгаль орчны аюултай үзэгдлийг мэдээлэх болон коодын зааварт өөрчлөлт оруулж, арга зүйн зөвлөлөөр хэлэлцүүлэн зааврыг шинэчлэн баталж, 2023 оны 07 дугаар сарын 01-нээс улсын сүлжээнд нэвтрүүлэхээр боллоо. Хэмжих хэрэгслийн шалгалт, тохируулга хуваарийн дагуу хийгдсэн. ЦҮОШГ-ын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 1, шууд захирагчийн 25 байгууллагын 2023 оны гурав дугаар улирлын “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтэд яамны үнэлгээний газраас хийсэн хяналт-шинжилгээгээр нийт 3276 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан 3115, хугацаа хоцорч оруулсан 66, мэдээ оруулаагүй 95, нийт үнэлгээ 95,1 хувиар дүгнэгдсэн байна. Хугацаа хоцорч оруулсан 66 мэдээллийн тухайд тухай бүр хугацаандаа мэдээллүүдээ оруулахад бүгд хугацаандаа оруулсан төлөвтэй байснаа дараа сард нь ороод үзэхэд ганц нэг мэдээллүүд нь хугацаа хоцорсон төлөвт шилжсэн байсныг шилэн дансны 71001111 утсаар лавлахад шилэн дансны системийн шинэчлэл, хөгжүүлэлттэй холбоотой алдаа гарсанг залруулж Яаманд албан тоотой хургуулж, тухайн байгууллагуудад мэдэгдсэн. Мэдээ оруулаагүй 7 байгууллагын 99 мэдээллийн тухайд 2022 оны 11 дүгээр сард БОАЖЯ-амаас зохион байгуулсан салбарын нягтлан бодогчдын нэгдсэн сургалт орсон мэргэжилтэн “шинэчилсэн шилэн дансны мэдээллийг оруулахдаа тухайн байгууллага зөвхөн өөрийн оруулдаг мэдээний тохиргоог сонгож оруулна” гэж мэдээлэл өгсний дагуу тохиргоогоо хийсний улмаас дээрх мэдээллүүд ил тод болоогүй, сайтад харагдахгүй байгаагаас мэдээ оруулаагүй тоонд багтсан байна.

Дээрх хоцролт болон мэдээ оруулаагүй нөхцөл байдал нь “Шилэн дансны цахим хуудас өөрчлөгдөж, системийн шинэчлэл, хөгжүүлэлт болон 2022 оны 11 дүгээр сард БОАЖЯ-амаас зохион байгуулсан салбарын нягтлан бодогчдын нэгдсэн сургалтаар шинэчилсэн шилэн дансны сайтад мэдээлэл оруулах талаар зөрүүтэй мэдээлэл өгснөөс шалтгаалсан байна.

Цаашид “Шилэн дансны тухай” хуулийн дагуу мэдээллийг ангилал тус бүрээр өөрийн цахим хуудас болон www.shilendans.gov.mn сайтад байршуулан иргэд, олон нийтэд мэдээллээ ил тод, хугацаа хоцруулалгүй хуулийн хугацаанд нь байршуулж байх талаар анхаарч ажиллахыг зөвлөсөн ба 7 байгууллагын 95 мэдээллийг нөхөж оруулуулсан. 4 дүгээр улиралд бүрэн хэрэгжүүлж ажиллаж байна .

Аймаг орон нутаг, харьяа байгууллагуудад хийгдэх аудитын төлөвлөгөөг боловсруулан батлуулав. Төв аймгийн албан хаагчаас ирүүлсэн өргөдөл гомдолын дагуу 2023 оны эхний хагас жилийн цалингийн болон жижиг сангийн гүйлгээний баримтанд хяналт шалгалт хийсэн. Илэрсэн зөрчил дутагдалыг холбогдох албан хаагчдад танилцуулж, дүгнэлтээ газрын даргад хүргүүлээ. Харьяа байгууллагуудын технологийн болон санхүүгийн аудит хийх ажил томилолтын зардал байхгүйгээс тасраад байна. Тус байгууллагын 2023 оны эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах ажлын хэсэг/цаашид комисс гэх/ Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллоготой холбоотой шийдвэр, холбогдох хууль, тогтоолын хүрээнд тус газрын даргын тушаалаар байгуулагдан 2023 оны 06 дугаар сарын 08-15-ний өдрүүдэд хийж, шинээр бүртгэгдсэн болон актлах эд хөрөнгийн жагсаалтыг гарган ТӨБЗГ-т хүргүүлэн холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэлээ. Жилийн эцэсийн тооллогын комиссыг байгуулан ажиллуулж байна.

Хавсралт хайрцаг 2. 9.6-ийн 1-ийн биелэлт

ДЦУБ-ын холбогдох газруудаас ирүүлсэн нийт 81 албан бичгийг холбогдох дарга, мэргэжилтнүүдэд хүргүүлж, чиглэл авч, санал солилцож, зөвлөгөө өгч ажиллав. Хоёр талт хамтын ажиллагаа болон болон гадаад орнуудын цаг уурын тоног төхөөрөмж үйлдвэрлэгч компаниудтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. БНХАУ-ын “Beijing Auxin Chemical Technology” компанид борооны пуужинг гаалиар нэвтрүүлэхэд шаардлагатай нэмэлт албан бичгүүдийг МУ-ын ГХЯ, Гаалийн ерөнхий газар, БНХАУ-д суулгаа МУ-ын элчин сайдын яам, ӨМӨЗО-ны Гаалийн газруудад хүргүүлж, пуужингийн лицензийг сунгалтыг хийлгэх, пуужинг Замын-Үүд боомтоор оруулах ажлыг зохион байгуулав.

Дэлхийн цаг уурын байгууллагын 19 дүгээр их хуралтай холбоотой асуудлаар БОАЖЯ-ама болон Гадаад харилцааны яамтай хамтран ажиллаж холбогдох албан бичиг хүргүүлж, мэдээллээр хангаж ажилласан. ДЦУБ дахь Монгол Улсын байнгын төлөөлөгчид Л.Оюунжаргал, ДЦУБ-ын МУ дахь Ус судлалын зөвлөхийг Д.Оюунбаатар нарыг ГХЯ-р дамжуулан томилуулах ажлыг зохион байгуулав.

Турк улсад болсон газар хөдлөлтийн гамшгийн хохирлыг даван туулахад Цаг уурын салбарын хэмжээнд 30.8 сая төгрөгийн хандив цуглуулж шилжүүлэн, эмгэнэлийн захидал илгээж ажилласан.

БОАЖЯ-ны Бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргатай хамт Туркийн элчин сайдтай уулзаж, Туркийн цаг уурын газарт салбарын мэргэжилтнүүдийг сургалтад хамруулах тухай хэлэлцэв.

Хавсралт хайрцаг 3. 9.6-ийн 2-ийн биелэлт

ДЦУБ-ын 19 дүгээр их хурал, сонгуультай холбоотой албан бичгүүд боловсруулж, сонгуульд Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа байнгын төлөөлөгчөөр дамжуулан санал өгүүлэх ажлыг зохион байгуулав. Холбогдох газар, хэлтсийн дарга, мэрэгжилтнүүд ДЦУБ-ын санхүүгийн зөвлөх хорооны 42 дугаар хурал болон гүйцэтгэх зөвлөлийн 76 дугаар их хуралд цахимаар, Арабын Нэгдсэн Эмират улсын Абу Даби хотноо болсон “ДЦУБ-ын 2 дугаар бүсийн орнуудын бага хурал”, БНХАУ-ын Цаг уурын газар хамтран Бээжин хотноо зохион байгуулсан “Бүх нийтэд зориулсан эрт зарлан мэдээлэх тогтолцоог сайжруулах нь” сэдэвт олон улсын хурал, Сингапур улсад Дэлхийн Цаг уурын байгууллагын азийн бүсийн төв салбарт зохион байгуулагдсан “Өндөр түвшний зөвлөгөөнд”-нд оролцож ажилласан. Хуралд оролцсон албан хаагчид “Бүс ба Зам”-ын хүрээнд эрт зарлан мэдээлэх мэдээг хүн бүрд хүргэх тухай Бээжингийн болон Абу Дабигийн тунхаглалыг батлалцснаас гадна “Монгол улсын цаг уурын ажиглалтын сүлжээ, мэдээлэл үйлчилгээний талаар” мэдээлэл хийв. Салбарын мэргэжилтнүүдийг гадаад хурал, сургалтад хамрагдах тухай 25, олон улсын хурал зохион байгуулахад шаардлагатай зардал гаргах тухай 4 тушаалын төсөл боловсруулж батлуулав. “Гадаад оронд албан томилолтоор ажиллах, суралцах журам”-ын хэрэгжилтийг хангуулж ажиллав. Салбарын нийт 58 ажилтныг гадаадад сургалт, хуралд хамруулж, гадаадад ажилласан алба хаагчдаар тайланг гаргуулж, олон нийтэд хүргэх мэдээлэл бэлтгэж ажиллав.

Хавсралт хайрцаг 4. 9.6-ийн 4-ийн биелэлт

9 дүгээр уулзалтын протоколын хэрэгжилтийг 2 талаас гарган нэгтгэв. Хоёр талын 10 дугаар уулзалт, 2023 оны 5 дугаар сарын 1-3-ны өдрүүдэд болов. Зохион байгуулалтын бүхий л бэлтгэл ажлыг хариуцан, албан бичиг, уулзалтын протокол, хөтөлбөрүүдийг англи, Монгол хэл дээр боловсруулах, зочдыг хүлээн авах, хурлын үйл ажиллагааны нарийн зохион байгуулалтын зүйлсийг хариуцан, Монголын талаас тавигдах илтгэлүүдийг хянан, илтгэл тавьж ажиллав. Ирэх 2 жилд Азийн шороон шуурганы мониторинг, загварчлалын арга технологийг сайжруулах, Цаг агаарын тоон прогнозын дэлхийн болон бүс нутгийн загварыг сайжруулах, Уур амьсгалын прогнозыг сайжруулах, Хөгжлийн албан ёсны тусламжийн хүрээнд төсөл хэрэгжүүлэх, Аянгын ажиглалтын сүлжээ бий болгох, Цаг уурын студийн талаар хамтран ажиллах гэрээг боловсруулав. Хөгжлийн албан тусламжийн ёсны хүрээнд хэрэгжүүлж буй “Цаг уурын мэдээллийн нэгдсэн систем үүсгэх, Өвөрхангай аймгийн төвд аэрологийн судалгааны станц суурилуулах” төслийн нээлтийн ёслолын үйл ажиллагааг “Үдлэг” харуул дээр зохион байгуулав. Энэхүү төслийн хэрэгжилттэй холбоотой удирдлага зохион байгуулалтыг хариуцан хурал уулзалтууд зохион байгуулж, албан бичгүүд боловсруулж, сургалтуудыг явуулж, холбон ажиллаж байна. KOICA -тай хамтран хэрэгжүүлж буй 3 жилийн төслийн хүрээнд 2023 оны 9 сард 25 хүнийг автомат станцын чиглэлээр сургалтад хамруулах ажлыг зохион байгуулав.

Хавсралт хайрцаг 5. 9.6-ийн 6-гийн биелэлт

БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй “Монгол Улсад цаг агаарын ажиглалтын нэгдсэн системийг суурилуулах” төслийн хүрээнд БНСУ-аас орж ирсэн тоног, төхөөрөмжүүдийн гаалийн бүрдүүлэлтэд шаардлагатай материалыг бүрдүүлж, барааг хүлээн авах ажлыг зохион байгуулав. “Beijing Auxin Chemical Technology” компаниас 1150 борооны пуужин, 22 пуужин хөөргөгчийн удирдлага худалдан авах гэрээ байгуулж, гэрэг орчуулах төлбөрийг шилжүүлэх, барааг хүлээж авахад шаардлагатай материалыг бүрдүүлэв. “CSIC Pride (Nanjing) Atmospheric & Oceans Information System” компанид “Цаг уурын радарын систем худалдаж авах, суурилуулах” ажлын хүрээнд радарын мэдээ ашиглалтын талаар сургалт зохион байгуулахаар ажиллаж байна. Францын “MODEM” компанитай 1400 зонд худалдан авах гэрээ байгуулж, гэрээг орчуулах төлбөрийг шилжүүлэх, зондыг хүлээж авахад шаардлагатай гаалийн материалыг бүрдүүлэн, барааг хүлээн авах ажлыг зохион байгуулав. БНХАУ-ын “China Huayun Meteorological Technology Group” корпорацитай супер компьютерын тендер, 20 дата логер, борооны пуужин худалдан авах талаар холбогдон ажиллав. Финландын “Vaisala Oyj” компанитай цаг уурын хэмжих хэрэгсэл худалдан авах гэрээ байгуулсан. Хэмжих хэрэгслийг худалдан авах гэрээг орчуулах, төлбөрийг шилжүүлэх, барааг хүлээж авахад шаардлагатай гаалийн материалыг бүрдүүлэн, барааг хүлээн авах ажлыг зохион байгуулав. Англи улсын eOsphere Limited компанитай. программ хангамжийн техник үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж үйлчилгээний төлбөрийг шилжүүлэхэд шаардлагатай материалыг бүрдүүлэв.